БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/171/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: С.Нурлан<br>Утас: 94209011 Цахим хаяг:Nurlans@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ **Error! Bookmark not defined.**
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11
3. Аудитын тайлан........ 12
3.1 Ерөнхий зүйл ........ 12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 13
3.4 Материаллаг байдал ........ 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........ 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 15
3.8 Аудитын гол асуудал ........ 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........ 16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ 16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........ 16
4. Аудитын илрүүлэлт ........ 17
4.1 Залруулсан алдаа........ 17
4.2 Төлбөрийн акт........ 17
Байхгүй ........ 17
4.3 Албан шаардлага ........ 17
4.4 Зөвлөмж ........ 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 17

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ УЛСЫН
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРУУДЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Ч.АСХАР ТАНАА

2022.02.11 № 37

танай ____________ -ны № ____________ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

МАНУТХГХЗ-dugnelt-2.07

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

МАНУТХГХЗ-dugnelt-2.07

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **25941578.00** | **38217778.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.00 | 0.00 |
| **32** | **БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 0.00 | 0.00 |
| **33** | **АВЛАГА** | 0.00 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 25941578.00 | 38217778.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 25941578.00 | 38217778.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 23800.00 | |
| 35420 | Аж ахуйн материал | 1234400.00 | 1234400.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 69500.00 | 69500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 210000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 0.00 | |
| 35460 | Хүнсний материал | 0.00 | |
| 35470 | Бусад хангамжийн материал | 24613878.00 | 36703878.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 35600 | Мал амьтад | 0.00 | 0.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 0.00 | 0.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **282914029.55** | **232112220.43** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 0.00 | 0.00 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 282914029.55 | 232112220.43 |
| 391 | Газар | 0.00 | 0.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 192905470.55 | 142103661.43 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 105510526.05 | 105510526.05 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -9998653.68 | -14997980.52 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 131885430.00 | 131885430.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -61121429.96 | -96503429.96 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 43096895.03 | 43096895.03 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -23130261.07 | -31929755.06 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9493614.40 | 9493614.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -4278859.36 | -5758965.13 |
| 39209 | Зам, гүрийн байгууламж | 842400.00 | 842400.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -842400.00 | -842400.00 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 0.00 | |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 0.00 | |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 704412.34 | 704412.34 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -234804.20 | -375686.72 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 0.00 | |
| 39217 | Ном | 978601.00 | 978601.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **393** | **Биет бус хөрөнгө** | 90008559.00 | 90008559.00 |
| 39301 | Программ хангамж | 550000.00 | 550000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550000.00 | -550000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 90008559.00 | 90008559.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | 0.00 |
| **394** | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | 0.00 | 0.00 |
| 39401 | Биологийн хөрөнгө /ТӨҮГ/ | 0.00 | 0.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **308855607.55** | **270329998.43** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **308855607.55** | **270329998.43** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **308855607.55** | 270329998.43 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 222757639.00 | 222757639.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 222757639.00 | 222757639.00 |
| 51102 | - хувийн | 0.00 | 0.00 |
| 51103 | - хувьцаат | 0.00 | 0.00 |
| 51104 | Халаасны хувьцаа | 0.00 | 0.00 |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал | 0.00 | 0.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 0.00 | 0.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 8298102.58 | -30227506.54 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 8298102.58 | 8298102.58 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -38525609.12 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 77799865.97 | 77799865.97 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | 0.00 | 0.00 |
| 51600 | Нөөцийн сан | 0.00 | 0.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **308855607.55** | **270329998.43** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **438,612,200.00** | **422,768,259.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **104,567,900.00** | **9,369,259.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 104,567,900.00 | 9,369,259.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 4,295,900.00 | 9,369,259.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,015,000.00 | 7,741,259.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал | 180,900.00 | 1,628,000.00 |
| 120005 | Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө | 100,272,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **334,044,300.00** | **413,399,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 332,544,300.00 | 409,899,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 332,544,300.00 | 409,899,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,500,000.00 | 3,500,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,500,000.00 | 3,500,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **398,462,324.49** | **461,293,868.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **398,462,324.49** | **461,293,868.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 374,571,909.69 | 361,790,374.04 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 231,703,301.14 | 224,704,597.91 |
| 210101 | Үндсэн цалин | 169,643,514.85 | 163,817,500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46,221,272.03 | 53,778,732.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,929,856.00 | 7,108,365.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 8,908,658.26 | - |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,837,900.00 | 32,838,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,108,200.00 | 23,108,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,432,400.00 | 2,432,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,946,000.00 | 1,946,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 486,400.00 | 486,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,864,900.00 | 4,864,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 6,012,950.50 | 5,021,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 600,000.00 | 600,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,412,950.50 | 4,421,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,125,166.20 | 9,936,215.45 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,185,020.00 | 738,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,572,090.00 | 8,249,730.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,274,391.00 | 927,585.45 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 235,600.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,858,065.20 | - |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 283,500.00 | 115,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 23,000.00 | 50,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 260,500.00 | 65,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,190,600.00 | 2,575,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,190,600.00 | 2,575,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,881,832.56 | 30,688,251.56 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,259,472.56 | 30,067,051.56 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 187,500.00 | 187,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 95,400.00 | 79,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,000.00 | 31,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 65,500.00 | 47,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 165,000.00 | 275,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 45,960.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 59,536,659.29 | 55,911,809.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,311,600.00 | 5,100,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 10,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 58,225,059.29 | 50,801,809.12 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,890,414.80 | 99,503,494.08 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 31,898,741.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 31,898,741.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 23,890,414.80 | 67,604,753.08 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,890,414.80 | 67,604,753.08 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **40,149,875.51** | **(38,525,609.12)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **40,149,875.51** | **(38,525,609.12)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | | 0.00 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **222,757,639.00** | **77,799,865.97** | **8,298,102.58** | 308,855,607.55 |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **222,757,639.00** | **77,799,865.97** | **8,298,102.58** | 308,855,607.55 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 0.00 | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **222,757,639.00** | **77,799,865.97** | **8,298,102.58** | 308,855,607.55 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | 0.00 | | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | -38,525,609.12 | -38,525,609.12 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **222,757,639.00** | **77,799,865.97** | **-30,227,506.54** | 270,329,998.43 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **338159300.00** | **421140259.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4115000.00** | **7741259.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4115000.00 | 7741259.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4115000.00 | 7741259.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4015000.00 | 7741259.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100000.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **334044300.00** | **413399000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 332544300.00 | 409899000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 332544300.00 | 409899000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1500000.00 | 3500000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1500000.00 | 3500000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **338159300.00** | **421140259.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **338159300.00** | **421140259.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **314268885.20** | **321636764.92** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 231703301.14 | 224704597.91 |
| 210101 | Үндсэн цалин | 169643514.85 | 163817500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46221272.03 | 53778732.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6929856.00 | 7108365.00 |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 8908658.26 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32837900.00 | 32838000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23108200.00 | 23108200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2432400.00 | 2432400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1946000.00 | 1946000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 486400.00 | 486500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4864900.00 | 4864900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5822800.00 | 5021500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 600000.00 | 600000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5222800.00 | 4421500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12391741.00 | 8410115.45 |
| 210401 | Бичиг хэрэг | 440400.00 | 207800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10579350.00 | 7177730.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1274391.00 | 927585.45 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 97600.00 | 97000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Норматив зардал** | 35000.00 | 35000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 35000.00 | 35000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 184300.00 | 130000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 184300.00 | 130000.00 |
| 210602 | Тавилга | | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2954600.00 | 2359000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2954600.00 | 2359000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 26790692.56 | 44618551.56 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25925832.56 | 44022351.56 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 187500.00 | 187500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108900.00 | 79500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95200.00 | 59400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 19800.00 | 19800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 407500.00 | 250000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 45960.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1548550.50 | 3520000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1416850.50 | 3500000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 131700.00 | 20000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23890414.80** | **99503494.08** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0.00 | 31898741.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 31898741.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 23890414.80 | 67604753.08 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23890414.80 | 67604753.08 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **0.00** | **0.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **0.00** | **0.00** |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | 0.00 | 0.00 |
| 226001 | Гадаад эх үүсвэрээр | | |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **0.00** | **0.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 14 | **Бусад эх үүсвэр** | 0.00 | 0.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |

| | | | |
|---|---|---|---|
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|
| | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 419922800.00 | 350035505.92 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 419922800.00 | 350035505.92 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 346426800.00 | 318136764.92 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 243243900.00 | 224704597.91 |
| Үндсэн цалин | 163817500.00 | 163817500.00 |
| Нэмэгдэл | 72222700.00 | 53778732.91 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 7203700.00 | 7108365.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32838000.00 | 32838000.00 |
| Тэтгэврийн даатгал | 23108200.00 | 23108200.00 |
| Тэтгэмжийн даатгал | 2432400.00 | 2432400.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1946000.00 | 1946000.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 486500.00 | 486500.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 4864900.00 | 4864900.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5186300.00 | 5021500.00 |
| Гэрэл, цахилгаан | 677800.00 | 600000.00 |
| Түлш, халаалт | 4421500.00 | 4421500.00 |
| Цэвэр, бохир ус | 87000.00 | |
| **Хангамж, бараа материалын зардал** | 10007000.00 | 8410115.45 |
| Бичиг хэрэг | 305200.00 | 207800.00 |
| Тээвэр, шатахуун | 8218200.00 | 7177730.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1386000.00 | 927585.45 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 97600.00 | 97000.00 |
| **Нормативт зардал** | 35000.00 | 35000.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 35000.00 | 35000.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 161600.00 | 130000.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 161600.00 | 130000.00 |
| **Томилолт, зочны зардал** | 2759500.00 | 2359000.00 |
| Дотоод албан томилолт | 2759500.00 | 2359000.00 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 52090100.00 | 44618551.56 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 51428700.00 | 44022351.56 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 187500.00 | 187500.00 |
| Даатгалын үйлчилгээ | 108900.00 | 79500.00 |

| | | |
|---|---|---|
| Тээврийн хэрэгслийн татвар | 95200.00 | 59400.00 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 19800.00 | 19800.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250000.00 | 250000.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 105400.00 | 20000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 105400.00 | 20000.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 73496000.00 | 31898741.00 |
| **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0.00 | 0.00 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 73496000.00 | 31898741.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 73496000.00 | 31898741.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 419922800.00 | 350035505.92 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 409899000.00 | 342294246.92 |
| Улсын төсвөөс санхүүжих | 409899000.00 | 342294246.92 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 10023800.00 | 7741259.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10023800.00 | 7741259.00 |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| Төсвөөс гадуур байгууллага | | |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 24.00 | 24.00 |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| Гүйцэтгэх ажилтан | 17.00 | 17.00 |
| Үйлчлэх ажилтан | 3.00 | 3.00 |
| Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **21.0** | **21.0** |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 18.00 | 18.00 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3.00 | 3.00 |
| Гэрээт ажилтан | | |
| Улс төрийн албан хаагч (УТ) | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх он** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3500000.00** | **3500000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3500000.00** | **3500000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3500000.00 | 3500000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3500000.00 | 3500000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3500000.00 | 3500000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3500000.00 | 3500000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3500000.00 | 3500000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3500000.00 | 3500000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №02/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа нь: Монгол Алтайн нурууны байгалийн бүс бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, байгалийн харьцангуй унаган төрхөөрөө байгаа үзэсгэлэнт хэв шинжийг хадгалах, ховор ховордсон ургамал, амьтан, цэвэр усны нөөц, түүх соёлын үл хөдлөх дурсгал бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах замаар хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг судлан таньж мэдэх, сөрөг нөлөөллийг бууруулах, зүй бус ашиглалтаас сэргийлж, хүний амьдрах таатай орчныг бүрдүүлж хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилго зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Дотоод аудит эрсдэлийн удирдлагын газраас харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийж заавар, зөвлөгөө өгч ажилладаг байна. Тус газарт 2021 онд дээрх газраас дотоод аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 398.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Монгол алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38.5 сая төгрөгөөр буюу 12.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|

| Б | 1 | 2 | 3=2-1 |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.00 |
| Бараа материал | 25,941.6 | 38,217.8 | 12,276.2 |
| Үндсэн хөрөнгө | 282,914.0 | 232,112.2 | -50,801.8 |
| **Нийт хөрөнгө** | **308,855.6** | **270,300.0** | **-38,526.6** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 308,855.6 | 270,330.0 | -37,525,6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **308,855.6** | **270,330.0** | **-38,525,6** |

Мөнгөн хөрөнгийн болон авлагын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 38.2 төгрөг болж 12.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 33.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй 1.6 сая төгрөгийн бараа материал хүлээн авч үйл ажиллагаандаа 22.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансанд өөрчлөлт гараагүй ба 50.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 270.3 сая төгрөг болж 38.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 38.5 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 422.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 15.8 сая төгрөгөөр буюу 6.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан санхүүжилтийн орлого нэмэгдэж, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 62.8 сая төгрөгөөр буюу 13.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, хангамж, бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Цалин, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд өмнөх оноос нэмэгдсэн бол хангамж, бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 412.7 сая төгрөг, тодотгосон төсөв 419.9 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 7.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 10,1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж бараа материалын зардал, байр ашиглалттай холбоотой зардал, эд хогшил, урсгал засвар, томилолт, зочны зардал, бараа

үйлчилгээний зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлуудыг нийтдээ 2,8 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 419.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 350.0 сая төгрөгийг зарцуулж, нийт дүнгээр 69.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага зардал гаргасан байна.

Оны эцэст 67.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь 2021 онд тэтгэвэрт гарах 2 байгаль хамгаалагч тэтгэвэрт гараагүйгээс тэтгэмжийн зардал 41.6 сая төгрөгөөр, цалингийн нэмэгдэл 18.4 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын 1.6 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой зардал 0.2 сая төгрөгөөр, томилолтын зардал 0.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал буюу байгаль орчныг нөхөн сэргээх, ургамал хамгааллын зардал 7.4 сая төгрөгөөр хэмнэлттэй гарсантай холбоотой байна.  Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын баримталж ажилласантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 10.0 сая төгрөг оруулахаас 7.7 сая төгрөг оруулж 2.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулан судалж үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийсэн байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 3.5 сая төгрөгийн орлого хүлээн авч, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой мэдээллүүдийг бүрэн толилуулан, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Тус газрын 2021 оны батлагдсан төсвийн 10 хувь 41.9 сая төгрөг бөгөөд 67.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнээс үзэхэд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна гэж үзлээ.

## 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд  тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Монгол алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайланд анхаарал татахуйц асуудал илрээгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монгол алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа нь 2021 онд нийт 419.9 сая төгрөгийн 119 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 419.9 сая төгрөгийн 108 мэдээллийг хугацаандаа, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Байгууллагын нягтлан бодогч нь 2021 оны 07, 08 дугаар сард ковидоор өвчилсний улмаас гэрийн хорионд тусгаарлагдан, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэнтэй холбоотой 7 дугаар сарын шилэн дансны мэдээллийг хугацааг хоцроож мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

**4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

**4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

**4.3 Албан шаардлага**

Байхгүй

**4.4 Зөвлөмж**

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | |